



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 06 сарын 18 өдөр

Дугаар А/350

Есөнбулаг сум

Улсын комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, 37 дугаар зүйлийн 37.1.6 дахь заалт, Засгийн газрын 2021 оны "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм шинэчлэн батлах тухай" 212 дугаар тогтоол, Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны "Барилга байгууламжийн төвөгшлийн ангиллыг зориулалт, хүчин чадлаар нь тогтоох дүрэм батлах тухай" 211 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Азийн хөгжлийн банкны "Хүнсний ногооны үйлдвэрлэл усалгаатай хөдөө аж ахуй" төслийн хүрээнд Жаргалан сумын Цахирын услалтын системийн ажлыг хүлээн авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга:	Д.Чинзориг	(Засаг даргын Тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга)
Гишүүдэд:	Б.Бямбадорж	(Аймгийн Ерөнхий архитектор)
	Л.Ганхуяг	(Орон нутгийн өмчийн газрын дарга)
	П.Хулан	(Төрийн Архивын хэлтсийн дарга)
	Д.Отгонжаргал	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Салбарын хяналт зохицуулалтын хэлтсийн эрчим Хүчний хяналтын улсын байцаагч)
	Г.Болд-Эрдэнэ	(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Геодези, зураг зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн)
	Д.Баярчулуун	(Алтай-Улиастай цахилгаан түгээх сүлжээ төрийн өмчит хувьцаат компанийн дэд станцын инженер)
	Х.Нордогбат	(Хүнс, хөдөө аж ахуйн газрын Газар тариалангийн үйлдвэрлэл, техник технологийн асуудал хариуцсан мэргэжилтэн)
	Р.Мөнхбаяр	(Жаргалан сумын Засаг дарга)
	С.Амгалан	(Жаргалан сумын Засаг даргын Тамгын газрын Хөдөө аж ахуйн тасгийн дарга, сумын төслийн хяналтын ажлын хэсгийн нарийн бичгийн дарга)

Ч.Раднаабазар	(Хүнс хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын Хуулийн хэлтсийн дарга)
Х.Кенжегүл	(Хүнс хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Газар тариалангийн технологи, усжуулалт хариуцсан шинжээч)
Л.Ундармаа	(Барилгын хөгжлийн төв төрийн өмчит үйлдвэрийн газрын Барилга байгууламж, техникийн захиалагчийн хяналтын хэлтсийн хяналтын инженер)
Г.Батбаяр	(Барилгын хөгжлийн төв төрийн өмчит үйлдвэрийн газрын Барилга байгууламж, техникийн захиалагчийн хяналтын хэлтсийн хяналтын инженер)
Г.Насандаваг	(“Эрчим хүчний үндэсний төв” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Захиалагч техник хяналтын хэлтсийн
Э.Наранмандах	цахилгааны хяналтын инженер) (Хүнс хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн яамны нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн инженер)
Б.Нямбаяр	(Хүнс хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн яамны нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн цахилгааны инженер,Зөвлөх)
Г.Ундрaм	(Хүнс хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн яамны нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн Байгаль орчин, нийгмийн хамгааллын мэргэжилтэн)
Ц.Батбаясгалан	(“Алтайн үндэс констракшн” ХХК-ийн захирал)
Г.Буян	(“Креавит энерги инженеринг” ХХК-ийн Зургийн инженер)
Ч.Батмөнх	(“Мөнгөн минж” ХХК-ийн төлөөлөл, усжуулалтын системийн зураг, төсөв зохиогч)
Нарийн бичгийн дарга: Ж.Очир	(Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

2.Услалтын системийн ажлыг ашиглалтад оруулахдаа гэрээнд тусгагдсан тоо хэмжээтэй нийцүүлэх, холбогдох баримт бичгийн бүрдлийг хүлээн авч үр дүнг танилцуулахыг комисс (Д.Чинзориг)-д үүрэг болгосугай.

3.Орон нутгийн өмчид бий болсон хөрөнгийг хүлээн авсан акт, баримт бичгийг үндэслэн хөрөнгийн хөдлөлт өөрчлөлтийг хийж, Барилгын тухай хуулийн 46 дугаар зүйлд заасны дагуу цаашдын ашиглалт, арчилгаа хамгаалалтад хяналт

тавьж ажиллахыг Жаргалан сумын Засаг дарга (Р.Мөнхбаяр), ашиглагч байгууллагад тус тус хариуцуулсугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ